

**ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ,
СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ҮЗЭГЧИЙН ГИШҮҮД
ӨВӨРХАНГАЙ, БАЯНХОНГОР АЙМГУУДАД
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН
АЖЛЫН ТАЙЛАН**

- **Хугацаа:** 2019 оны 4 дүгээр сарын 22-ноос 26-ны өдрүүд
- **Хамрагдсан газрууд:** Өвөрхангай, Баянхонгор аймгууд
 1. Эрүүл Мэндийн Газар
 2. Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв/Нэгдсэн Эмнэлэг
 3. МӨАУМХолбоо
- **Ажилласан бүрэлдэхүүн:**
 1. Ж.Мөнхжаргал, ҮЗЗ-ийн төрийн байгууллагын төлөөлөл
 2. А.Цэцэгмаа, ҮЗЗ-ийн ОУБ-ын төлөөлөл
 3. Б.Сувд, ҮЗЗ-ийн ТББ-ын төлөөлөл
 4. Н.Цогзолмаа, Глобаль сангийн дэмжлэгтэй төслүүдийн зохицуулагч
 5. С.Ганзаяа, Глобаль сангийн сүрьеэгийн төслийн мэргэжилтэн
 6. Б.Оюунбэлэг, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА-ны эмч
 7. Д.Отгонцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны их эмч
 8. Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч

Зорилго

Төсөл хөтөлбөр саадгүй, цаг хугацаандаа, хүрэх ёстой газраа хүрч хэрэгжиж байгаа эсэхэд дэмжлэгт хяналт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.


- Үйл ажиллагаатай танилцах
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт
- Амжилт, саад бэрхшээл
- Хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж

Сүрьеэгийн тархалтаар

- **Баянхонгор аймаг** сүрьеэгийн өвчлөл дунд түвшний аймгийн нэг бөгөөд 2018 оны статистик тайлангаар сүрьеэгийн тохиолдлын түвшин 10 000 хүн амд 7.2 байгаа ба 2014 оноос хойш бүртгэгдсэн тохиолдлын түвшин тогтмол нэмэгдэж байна. Тус аймагт сүрьеэд өртөх өндөр эсдэлт бүлэгт ордог бичил уурхай олон тоогоор ажилладаг.
- **Өвөрхангай аймаг** сүрьеэгийн өвчлөл бага аймагт ордог, СТСА-ны 2018 оны тайлангаар 10 000 хүн амд сүрьеэгийн тохиолдлын түвшин 3.5 байгаа нь улсын дундажаас (10 000 хүн амд 11.3) болон аймгийн дундажаас бага (10 000 хүн амд 8.4) сүүлийн 5 жилд сүрьеэгийн тохиолдлын түвшин 10 000 хүн амд 2014 онд 6.1, 2018 онд 3.5 байгаа нь буурч буйг харуулж байна.

БЗДХ-ын тархалтаар

- **Баянхонгор аймгийн бэлгийн замаар дамжих халдвар 2019 оны эхний улиралд 10,000 хүн амд ногдох**
 - Тэмбүүгийн тохиолдлын түвшин 5.9 (улсын дундаж 4.2),
 - Заг хүйтэн 22.9 (улсын дундаж 4.2-оос 5 дахин өндөр) трихомониаз 17.8 (улсын дундаж 3.2-оос 5 дахин өндөр), байгаа төдийгүй өмнөх оны мөн үеэс 2-4 дахин өндөр бүртгэгдсэн байна.
- **Өвөрхангай аймгийн**
- **2018 оны байдлаар 10,000 хүн амд ногдох**
 - Тэмбүүгийн тохиолдлын түвшин 16.1 (улсын дундаж 19.4),
 - Заг хүйтэн 9.7 (улсын дундаж 17.2) трихомониаз 7.6 (улсын дундаж 14.1), байгаа төдийгүй ХДХВ-ын 1 халдвар бүртгэгдсэн байна.



Өвөрхангай аймаг

Зөөврийн рентген аппарат	<ul style="list-style-type: none">• 2000 хүнд у.с үзлэг• 2 шинэ тох илрүүлсэн• У.с үзлэгийг 1 техникч 900 орчим хүний зургийг 1 зэрэг авдаг.
БЗДХ Шинэ байр!	<ul style="list-style-type: none">• Бэлгэвч, урвалжийн ханган нийлүүлэлт буурсан• Эм.үзлэгийн ор хуучирсан• Өсгөвөрийн шинжилгээ хийдэггүй• Термостат эвдэрсэн• Суурин компьютерийг нь БОЭТ авсан
МӨАУМХОЛБОО	<ul style="list-style-type: none">• Өрхийн эмнэлэгт хөтлөгдвөл зохих бүх журнал хөтөлдөг• Өвчтөний эмийг сар сараар нь сүрьеэгийн диспансераас хүлээн авч хянаж уулгадаг• Цэрний сорьц цуглуулах сав, зөөвөрлөх саваар хангагдсан

Баянхонгор аймаг

Зөөврийн рентген аппарат	<ul style="list-style-type: none">• Рентген аппарат хэрэглээгүй
БЗДХ	<ul style="list-style-type: none">• Засвар хийгдсэн байга ч агааржуулалт хангалтгүй, бохир үнэртсэн• Нэг үзлэгийн өрөө, нэг эмч тусламж үйлчилгээ үзүүлж байгаа нь чирэгдэл их• 2019 оны эхний улирлын ХӨСҮТ-ийн Нэгдсэн лабораторын алба /НЛА/-ны БЗДХ-ын лабораторит чанарын дотоод хяналтын шинжилгээнд илгээсэн сорьцуудын онош зөрсөн, хяналтын шинжилгээнд сорьц илгээх журам алдагдсан, хуурамч эерэг , сөрөг хариу гаргах зэрэг зөрчлүүд илэрсэн.
МӨАУМХ	<ul style="list-style-type: none">• Сорьцны сав байхгүй тул сорьц тэвэрлэхэд хүндрэлтэй• Уушигны сэрвээгийн тохиолдол 1 бүртгэгдсэн ба эм уух буланд эмийг нь уулгадаг ба зарим тохиолдолд гэрээр эмийг зөөдөг